

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ /2007 оны 3 дугаар сар/

### Нийгмийн хамгааллын салбарт:

“Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил”-ийн ажлыг зохион байгуулж байгаа тухай Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, жилийн жилийн ажлыг зохион байгуулахад зориулан 90.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2007 оны төсвийн орлогын 0.3 хувийг бүрэн төвлөрүүлэх, 2006 оны жилийн эцсийн үлдэгдэл 2.0 тэрбум төгрөгийг уг санд оруулахаар шийдвэрлэв.

Эрэлтэд тулгуурласан мэргэжлийн сургалтад 11.5 мянга, аж ахуйн эрхлэлтийн сургалтад 7.3 мянган хүнийг хамруулан сургаж, ажлын байр шинээр бий болгох зорилгоор 5.5 тэрбум төгрөгийн жижиг зээл олгоно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, УИХ-д өргөн барихаар тогтов.

2007 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг Засгийн газрын 2007 оны 58 дугаар тогтоолоор баталлаа.

“Кувейтийн сан”-гийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Эрдэнэт-Булган-Уньтын чиглэлийн 146 км хатуу хучилттай замын төслийн гүйцэтгэгч Кувейт Улсын “Комбайнд” группын 45 ажилтан, “Кувейтийн сан”, “Абу Даби” хөгжлийн сангийн зээлийн хөрөнгөөр Тайширын усан цахилгаан станцыг барьж байгаа БНХАУ-ын “Синохайдро” корпорацийн 450 ажилтан, “Камко интернейшнл” компанийн 182 ажилтан, Дөргөний усан цахилгаан станцын барилга-угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа БНХАУ-ын гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны “Шанхай” группын 275 ажилтан, ХБНГУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Богдын голын усан цахилгаан станцын шинэчлэлийн төсөл”-ийн гүйцэтгэгч БНХАУ-ын “Шар мөрөн, Ляо мөрний барилгын товчоо”-ны 48 ажилтан, Дорнод аймгийн Тамсагийн сав газар, Дорноговь аймгийн Зүүнбаянгийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 3620 ажилтан, “Доншен” ХХК”-ийн 480 инженер-техникийн болон мэргэжлийн ажилтныг 2007 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх, мөн хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын 2007 оны 59 дүгээр тогтоолоор шийдвэрлэв.

“Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, түүнийг 2006-2008 онуудад хэрэгжүүлэх Засгийн газрын төлөвлөгөөний хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх төрийн зарим үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэх зорилгоор “Монголын хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбоо”-той гэрээ байгуулав.

ОУХБ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчин” сэдэвт Үндэсний семинарыг Төрийн ордонд зохион байгуулав.

“Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авав. Уг арга хэмжээнд нийт 4614 тэтгэвэр авагчийг хамруулахад 1.3 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдах бөгөөд үүний 73.7 хувь буюу 957.9 сая төгрөгийг 2007 онд олгох тооцоо гарч байна. 2006 оны сүүлийн хагас жилд хөдөө аж ахуй нэгдлийн гишүүний хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр 27000 төгрөг, 2007 онд 34500 төгрөгийн тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагчдын тэтгэврийг бүрэн тэтгэврийн доод хэмжээ 51750 төгрөгт хүргэснээр нэг хүнд сард 13000-17250 төгрөгийн орлого нэмэгдэж байна.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2007-2011 онд хэрэгжүүлэх “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Хүн ам ба хөгжил, жендэрийн асуудлыг ядууралтай холбох нь” төслийн баримт бичигт НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгч болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нар гарын үсэг зурж, баталгаажуулав.

Хүүхэд бүрийг гэр бүлийн орчинд хүмүүжүүлэх, хамгаалах, хөгжүүлэх бодлогыг боловсронгуй болгох, гэр бүл, эцэг эхийн хүүхдийн төлөө хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх улмаар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор “Монголын үрс-эцэг, эхтэйгээ” үндэсний чуулганыг Хүүхдийн төлөө үндэсний газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран Улаанбаатар хот, Баян-Өлгий, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай аймгийн төвд 2007 оны 3 дугаар сарын 08-ны өдөр нэгэн зэрэг зохион байгууллаа. Үндэсний чуулганд Ерөнхий сайд, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгч, УИХ, Засгийн газрын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, хүүхдүүдийн төлөөлөгчид оролцож, “Монголын үрс эцэг, эхтэйгээ” жилийн аяны удирдамжийн төслийг хэлэлцэж, батлав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь Төлөөлөгчийн газрын дарга ноён Лин Хэнг Тунг, мөн газрын төлөөлөгч Алберт Хуанг болон Казахстаны Төлөөлөгчийн газрын хэргийг түр хамаарагч Ноён Асхад Сыздыков нартай уулзалт хийв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын урилгаар БНТУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Энис Еэтэр 4 дүгээр сард Монгол Улсад айлчлахтай холбогдуулан айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хөтөлбөрийг Монгол дахь БНТУ-ын ЭСЯ-нд хүргүүлэв.

ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн Товчооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Дэбра Пэрри, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эрх зүйн хүрээнд дэмжих нь” хөтөлбөрийн зохицуулагч Эмма Ховель нар албан томилолтоор ажиллав.

Боловсролын салбарт:

Мэргэжлийн боловсролын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг зах зээлийн нөхцөлд нийцүүлэх зорилгоор “Мэргэжлийн боловсролын тухай” хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг шинэчлэн байгууллаа.

“Үр дүнд түргэн хүргэх санаачилга” төслөөс 2007 оноос Боловсролын салбарт хэрэгжүүлэх 8.2 сая долларын өртөгтэй дөрвөн талт хамтын ажиллагааны Санамж бичигт Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Япон Улсын Элчин сайдын яам, Дэлхийн Банк, Азийн хөгжлийн банкны удирдлагууд гарын үсэг зурав.

“Чингис хаан ба түүний залгамжлагчид” үзэсгэлэнг энэ оноос Унгар Улсад үзүүлэхээр харилцан тохиролцож, хоёр тал гэрээнд гарын үсэг зурлаа.

Мөн Испани Улсад зохион байгуулагдах “Монголын нэг өдөр” үзэсгэлэнгийн гэрээний төслийг хэлэлцэж, үзэсгэлэнд оролцох үзмэрийн 80 хувийн фото зургийг авч хүргүүлээд байна.

Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан "Дүрслэх урлагийн шилдэг бүтээл улсын санд худалдан авах журам"-ын дагуу 7 бүтээлийг улсын санд худалдан авлаа.

“Шилдэг ном-2006” сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нийт 87 нэрийн номыг улсын санд авч аймаг, нийслэл, сумдад түгээж эхэллээ.

“Соёл, урлагийн ажилтны мэргэшил дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу сумдын номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтад төв орон нутгийн 30 номын санч оролцлоо.

Монголын Зохиолчдын эвлэлтэй хамтран “Монголын уран зохиолын өнөөгийн байдал, чиг хандлага” сэдэвт онол-практикийн бага хурлыг зохион байгууллаа. Онол практикийн хурал дээр “Төрөөс ном хэвлэл, утга зохиолын талаар баримтлаж буй бодлого, түүний хэрэгжилт”, “Монголын уран зохиолын өнөөгийн байдал, чиг хандлага”, “Хүүхдийн уран зохиолын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”, “Дэлхийн сонгодог уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага, цаашдын чиг хандлага”, “Жүжгийн зохиолын шинэчлэл ба ядуурал” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.

Франц улсад зохион байгуулагдсан Милош Магины нэрэмжит Олон улсын төгөлдөр хуурчдын XII дахь удаагийн уралдаанд хөгжим бүжгийн коллежийн багш Ч.Тунгалаг, сурагч Б.Бат-Эрдэнэ нар оролцож тэргүүн байр эзэллээ.

Шинжлэх ухаан технологийн хөгжилд залуу эрдэмтдийн хувь нэмрийг оруулах, тэдний бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, урамшуулах зорилгоор нэр бүхий 11 ажилтанд тус бүр 2.0 сая төгрөгийн грантыг БСШУ-ны сайдын тушаалаар олголоо.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс “40000 орон сууц” хөтөлбөрт 5000 албан хаагчийг хамруулахаар БХБЯ, БСШУЯ хооронд “Хамтран ажиллах гэрээ”, хамтарсан ажлын хэсгийг байгуулж, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан салбарын болон яамны албан хаагчдын орон сууцны дэлгэрэнгүй судалгааг авч эхлээд байна.

Эрүүл мэндийн салбарт:

ЭМЯ, НҮБ-ын Хүн амын сан, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран “Жирэмсний үеийн тусламж үйлчилгээг бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ-ын халдварыг оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээтэй нэгтгэх төсөл”-ийн хүрээнд Ховд, Төв, Сэлэнгэ, Өмнөговь аймгуудын Нэгдсэн эмнэлэг, Ховд аймгийн Манхан, Төв аймгийн Эрдэнэ сумын эмнэлэг, Баянзүрх, Налайх дүүргийн эмнэлэг, Нэгдүгээр амаржих газарт нийт 97.6 сая төгрөгийн үнэ бүхий лабораторийн багаж, хэрэгслийг хуваарилав.

“Сум, сум дундын эмнэлэгт шилжин ажиллах их эмчид урамшуулал олгох журам”, “Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийг хүний их эмч болон сувилагчийн мэргэжлээр төгсөж сум, сум дундын эмнэлэгт ажиллах оюутанд сургалтын тэтгэлэг олгох журам”, “Сум, сум дундын эмнэлэгт шилжин ажиллах их эмчтэй байгуулах гэрээ”-ний загвар, “Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх сургуулийг хүний их эмч болон сувилагчийн мэргэжлээр төгсөж сум, сум дундын эмнэлэгт ажиллах оюутантай байгуулах гэрээ”-ний загвар, эмч, оюутныг сонгон шалгаруулж сум, сум дундын эмнэлэгт ажиллуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тус тус батлав.

2007 оны эхний 6 сард шаардагдах заавал хийх дархлаажуулалтын вакцины захиалгыг хийн Японы ЖАЙКА байгууллагад хүргүүлсэн.

“Эрүүл мэндийн удирдах ажилтны улсын зөвлөлгөөн”, “Өрхийн эмнэлгийн хоёрдугаар чуулга уулзалт-ыг Улаанбаатар хотод зохион байгуулав.

2007 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар “Монголэмимпекс” ХК-ны агуулахад 166 нэрийн 536.0 сая төгрөгийн, орон нутгийн Эм хангамж компаниудын агуулахад 37-153 нэрийн 500.2 сая төгрөгийн ҮЗШЭ-ийн үлдэгдэлтэй байна. ҮЗШЭ-ийн хангамж нэр төрлөөр Улаанбаатар хотод 60%, хөдөө орон нутагт 40.0-55.0%-тай байна.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны тайлан, үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 2006 оны төсвийн гүйцэтгэлийн хамт УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв.

Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй 35 төсөл, түүний хэрэгжүүлэгч байгууллагын жагсаалт, Төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын түр журмыг баталлаа.

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн авто зам” төслийн шугамаар 2007 онд гаалийн болон нэмэгдсэн өртгийн татваргүйгээр импортлох 57 нэр төрлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын жагсаалтыг баталж, улсын хилээр оруулах зөвшөөрлийг олголоо.

Улсын төсвийн 2006 оны жилийн эцсийн гүйцэтгэл буюу мөнгөн гүйлгээний тайлан, түүнчлэн улсын төсвийн байгууллагын авлага, өглөгийн тайланг нэгтгэн

боловсруулж дууслаа. Монгол улсын 2006 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 1.360.0 тэрбум, нийт зарлага 1.209.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 262.8 тэрбум төгрөгөөр буюу 23.9 хувиар давж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 522.6 тэрбум төгрөгөөр буюу 62.3 хувиар өссөн байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн дүнгээр 2006 онд нийт төсөвт байгууллага 51.8 тэрбум төгрөгийн өглөгтэй, 267.4 тэрбум төгрөгийн авлагатай гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өглөг 45.7 сая, авлага 223.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын нэгдсэн төсөвт 2007 оны хоёрдугаар сард нийт 213.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 233.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 20.1 тэрбум төгрөгөөр буюу 9.4 хувиар давуулан биелүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 133.4 тэрбум төгрөгөөр буюу 66.1 хувиар илүү байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага 2007 оны хоёрдугаар сард 150.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зарлагын 65.6 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 32.9 тэрбум төгрөгөөр буюу 27.9 хувиар илүү байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 0.6 тэрбум төгрөгөөр тасарч, зарлага 3.8 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2007 оны 2 дугаар сарын урсгал тэнцэл 92.9 тэрбум, нийт тэнцэл 82.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу 2007 оны нэгдүгээр улиралд улс, орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, нийт 215.9 тэрбум төгрөгийн эрх нээхээс 205.8 тэрбум төгрөгийн урсгал санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна.

2007 оны эхний улиралд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (өссөн дүнгээр) 7.331.4 сая (тухайн сард 4.568.2 сая) төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах байгууламж” болон “Холбоо, хяналт, мэдээллийн сүлжээ” төслийн зээлийн хэлэлцээг Солонгосын “Экспорт, импорт банк”-тай явуулж, гэрээг үзэглэв.

Монгол Улсын Засгийн газар, Бельгийн Вант Улсын Засгийн газар хоорондын “Зүүн бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх төсөл”-ийн зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажууллаа.

Япон Улсын Засгийн газрын шугамаар 2006 оны санхүүгийн жилд үзүүлэхээр болсон 800.0 сая иенийн нефть бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, борлуулах, тусламжийн санд орлого төвлөрүүлэх ажлын гүйцэтгэгч “ЖАСТ” ХХК, “Петровис” ХХК-тай гэрээ байгуулж, гарын үсэг зурсан байна.

Барилга, хот байгуулалтын салбарт:

“Мянганы сорилын сан” төслийн хүрээнд хэрэгжиж буй “Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл” төслийг АНУ-аас ирсэн экспертүүдтэй хамтран боловсруулж байна.

Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Эрхүү хотноо ажлын айлчлал хийв.

Улаанбаатар хотын гэр хорооллын нэмэгдсэн хэсгийн 1:1000 масштабтай кадастрын зураглал, Төв аймгийн сумдын 1:25000 масштабтай кадастрын зураглал ба газрын бүртгэлийн ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулав.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран Хөөсөн полистрол хавтангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийж байна.

Улсын болон орон нутгийн, хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн 8 объектын инженер-геологийн судалгааны ажилд экспертиз хийж дүгнэлт гаргав.

Төрийн нарийн бичгийн дарга Ц.Ганхүү тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-ын Сокчо хотод ажлын айлчлал хийж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

Монгол Улсын Орон Сууцны санхүүжилтийн корпораци, БНСУ-ын Орон сууцны санхүүжилтийн корпораци хооронд хамтын ажиллагаа тогтоохоор Санамж бичгийн төслийг уг байгууллагад хүргүүлэв.

Барилгын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Их бүтээн байгуулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх нь”, Нийтийн аж ахуйн удирдах ажилтны зөвлөгөөнийг “Нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэл” уриан дор Улаанбаатар хотод тус тус зохион байгуулав. Мөн Барилга, хот байгуулалтын яам, харьяа агентлагууд Япон Улсын Шинжлэх ухаан, технологийн агентлагтай хамтран “Газар хөдлөлтийн аюулыг бууруулах нь” сэдэвт олон улсын семинар зохион байгуулав.

Германы Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хараа голын ай савын менежмент” төслийн санамж бичигт Германы тал болон Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Байгаль орчны яамд гарын үсэг зурж, төслийг эхлүүлэв.

Үйлдвэр, худалдааны салбарт:

Монгол Улс, АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн 3 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Монгол Улсаас тус хөнгөлөлтийн системд хамруулах сонирхол бүхий бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг АНУ-ын талд өгөв.

НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн Комисс /UNESCAP/-той хамтран “ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндэсний инновацийн тогтолцоо, технологи хөгжүүлэх бодлого” сэдэвт семинарыг зохион байгууллаа.

Боловсруулах салбарын орон тооны бус шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, 2006 онд хэрэгжиж дууссан 4 төслийн тайлан, 2008 онд шинээр захиалах 26 төслийн саналыг хэлэлцэж шийдвэрлэв.

Монгол орны ураны хүдрийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай саналыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийн дагуу ажлын хэсэг ажиллаж байна.

Үйлдвэр, худалдааны Дэд сайд Налайх дүүрэгт ажиллаж гар аргаар нүүрс олборлож байгаа иргэдтэй уулзалт зохион байгуулав.

Экспортын татварыг цуцлах асуудлаар ДХБ-д авсан үүрэг амлалтын хэрэгжилтийн хугацааг сунгах талаар дэмжлэг хүссэн захидлыг ЕХ, АНУ, БНХАУ, Япон, Швейцарь, Бельги, Энэтхэг улсад суугаа Элчин сайд, Байнгын төлөөлөгч нарт явууллаа.

Газрын тосны салбарт үүсээд буй нөхцөл байдал, цаашид авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргав.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

“Хөдөө аж ахуйн усжуулагчдын улсын зөвлөгөөн”-ийг зохион байгуулав.

Үлийн цагаан оготны хаврын тархалт, хөнөөлийн тодотгох судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх гэрээг УХЭШХ-тэй байгуулан, судалгаанд нийт 4 аймгийн 44 сумыг хамруулахаар шийдвэрлээд байна.

ОХУ-аас эхний ээлжинд нийлүүлсэн 682 тн буудайг хүлээн авлаа.

БНХАУ-ын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн бага оврын 58 тракторыг иж бүрдлийн хамт, 1 га-гийн услах систем 9, 25 га-гийн услах систем 5-ыг тус тус борлуулж санг бүрдүүлээд байна.

Япон улсын буцалтгүй тусламжийн 9226.5 тонн буудайг 10 гаруй аж ахуйн нэгж, иргэнд борлуулж “КР-1” хуримтлалын санд төвлөрүүлээд байна. Мөн 9600 тонн дотоодын буудайг борлууллаа.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин нийлүүлэгчийг сонгох МЭТШ07/01/07 тоот тендерийг зарлав.

Хонины гоц халдварт цэцэг өвчний голомт бүхий аймаг, сумдын хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг татан буулгав. Өвчин гарсан болон түүнтэй хил залгаа аймаг, сумдын 1.8 сая хонийг цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулав.

Шувууны томуу, хүний томуугийн цар тахлаас сэргийлэх үйл ажиллагааны 2007–2009 оны төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв. Дэлхийн Банкнаас энэ үйл ажиллагаанд 3.0 сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр тогтов.

Засгийн газрын 2006 оны 178 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Улаанбаатар хот, зарим аймгийн хүн амын махны хангамжийг сайжруулах зорилгоор нөөцөлсөн махыг 3 дугаар сарын 15-наас орон нутгийн Засаг даргын Тамгын газраас баталсан хуваарийн дагуу борлуулж эхлэв.

“Хөдөөгийн ядуурлыг бууруулах стратеги ба Монголын хөдөөгийн хөгжил” сэдэвт семинарыг ХААХОУС-тай хамтран зохион байгуулав.

НҮБ-ын ХХААБ-ын Бээжин дэх суурин төлөөлөгч хатагтай Виктория Секитолемо тэргүүтэй төлөөлөгчдийн Монголд хийсэн айлчлалын үеэр ХХААБ-ын суурин төлөөлөгч Хүнс, хөдөө аж ахуйн сайдад Итгэмжлэх Жуух Бичгээ барив.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн салбарын судалгааны төсөл”-ийн “Малчдын амьжиргаа” хэсгийн судалгааны багтай хамтран төсөлд хамрагдах аймгуудад судалгаа хийлээ.

Түлш, эрчим хүчний салбарт:

Салбарын шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар Өмнөговь аймгийн Номгон, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Идэр, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Говь-Алтай аймгийн Гуулин тосгон, Дорноговь аймгийн Хамрын хийд, Архангай аймгийн Мөрөн багийн төвийг цахилгаан эрчим хүчээр хангах техник эдийн засгийн үндэслэл, орон нутгийн хэрэглэгчдийг бага оврын нэг фазын трансформатраар хангах төсөл, Хөвсгөл, Дундговь, Архангай аймгийн төв, сум, суурин газрын дулаан хангамжийн судалгааны тайлан, Улаанбаатар-Мандалговь-Оюутолгойн 220 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, “Экологийн цэвэр түлшний үйлдвэрийн төсөл”, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл, 2007 онд шинээр баригдах цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний техник, эдийн засгийн үндэслэлийг тус тус хэлэлцэн шийдвэрлэлээ.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах” төслийн 2007 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

Мөн Дэлхийн банкнаас Дорнод аймагт хэрэгжүүлэх дулааны шугамыг шинэчлэх төслийн тендерийг зарлаад байна.

БНСУ-ын “Дэсонг” групп, Түлш, эрчим хүчний яам хооронд “Сэргээгдэх эрчим хүчний парк байгуулах тухай” санамж бичиг байгууллаа.

2007 онд хэрэгжих зээлийн 1.7 сая ам.доллар, тусламжийн 304.0 мянган еврогийн төслийн гүйцэтгэлийг Сангийн яаманд уламжилж санхүүжилтийг хийлгэв.

“Монгол Улсыг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Хөвсгөл аймгийн Жаргалант-Галт сумын 10 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга угсралтын үе шатны ажлын АКТ№01 гүйцэтгэлийг 219.8 сая төгрөгөөр санхүүжүүлээд байна.

Улсын төсвөөс алдагдлын санхүүжилт авдаг дизель станц бүхий Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдийн 2007 онд худалдан авах дизель түлшний нийлүүлэгчээр “НИК”, “Петровис” ХХК-ийг шалгаруулж гэрээг байгуулан 1, 2, 3 дугаар сарын хуваарьт 1866.08 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

2007 онд улсын төсвийн болон “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төсөл, арга хэмжээний урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээг байгууллаа.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн автовокзал, автомашины зогсоол бүхий төмөр замд шууд холбогдсон авто тээврийн терминал-аж ахуй байгуулах зургийн даалгаврыг батлан, уг объектыг барих аж ахуйн нэгжийг сонгох тендер зарлан, үнэлгээний хороог байгуулав.

Ховд, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймгуудын нисэх буудлуудад олон улсын нислэг үйлдэхэд хил, гааль, мэргэжлийн хяналтын болон бусад байгууллагууд үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэв.

“Олон улсын агаарын тээврийг либералчлах тухай олон талт хэлэлцээр”, түүний “Зөвхөн агаараар ачаа тээвэрлэхэд хэрэглэх тухай нэмэлт, өөрчлөлт”-д Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв. Энэ оны 2 дугаар сарын 22-ны өдөр Парис хотноо “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав.

Хот хооронд болон аймаг, сумын хоорондох шуудан тээвэрлэлттэй холбоотой асуудлаар ЗТАЖЯ-ны Тээврийн газар, Тээврийн үйлчилгээний төв, “Монголшуудан” компанийн уулзалтыг зохион байгуулж, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлуудаар харилцан тохиролцов.

Авто замын засвар, арчлалтын ажлын чанарыг сайжруулах, бусад дэвшилтэт технологийн талаар ЗТАЖЯ-ны Авто замын газар, СХОХАГ, орон нутгийн авто замын засвар арчлалтын ажлыг хариуцдаг байгууллагуудын удирдах ажилтны уулзалт семинарыг зохион байгуулж, тулгамдсан асуудлын талаар ярилцав.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Зүүн чиглэлийн гол авто зам барих, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн “Иточу” компанитай байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдэх 450.0 сая иенийн үнэ бүхий машин, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэв.

Герман Улсын “KfW” банкны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд зээлийн үлдэгдэл 112.0 мянган ам. долларын хөрөнгөөр Сэлэнгэ аймгийн Түнхэл сумын 2 км замыг сайжруулах тухай хвсэлтийг Германы талд тавив.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Тээвэр хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх Хархорин-Цэцэрлэг чиглэлийн хэсэгчилсэн хайрган хучилттай авто замын барилгын ажлын 5 дугаар багцын үнэлгээг дахин хийж Дэлхийн банкнаас зөвшөөрөл аван гэрээ байгуулж байна.

БНХАУ-ын жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялуулах аялал жуулчлалын байгууллагад эрх олгох журмыг шинэчлэн, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдэд зориулсан зөвлөмжийн төсөл, Хустайн цогцолборт газрын “Орчны бүсэд тогтвортой амьжиргааг хөгжүүлэх”, “Бэлчээрийн тогтвортой менежмент”, “Монголын Алтай, Соёны Эко бүс нутгийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах” болон “Байгалийн нөөцийн тогтвортой менежмент”-ийн төслийг боловсруулж батлав.

Замын-Үүд-Эрээний хооронд байнгын зорчигч тээвэрлэлтийг стандартын шаардлага хангасан, том оврын автобусаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэлээ.

Аялал жуулчлалын улирал эхэлж байгаатай холбогдуулан “Жуулчин” таних тэмдгийг тээврийн үйлчилгээ эрхлэх стандартын шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгсэлд олгох ажлыг зохион байгуулж байна.

Замын цагдаагийн гэрээт тасгийн хяналт, шалгалтын ажилд зориулж 1 автомашин, явуулын оношлогооны зориулалтаар 4 автомашиныг Улаанбаатар хот, Дундговь, Төв, Дорноговь аймгийн салбаруудад хвлээлгэн өгсөн.

БНСУ-ын “Кореа пост” байгууллага, “Монголшуудан” ХК-ийн хооронд хамтран ажиллах санамж бичигт талууд гарын үсэг зурав.

Дэлхийн банкны Тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд хэрэгжих “Авто замын сүлжээг хөгжүүлэх (2020 он) ерөнхий төлөвлөгөө”, баруун аймгуудын замуудаас сонгож авсан

хэсгүүдэд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах тухай гэрээнд Австрали Улсын “SMEC” компанитай гарын үсэг зурж ажлыг эхлүүлэв.

Хан-Уул дүүргийн Сонгинын амралтын дэргэдэх Туул голын 206 у/м модон гүүрийг ашиглалтад хүлээн авлаа.

“Өвлийн аялал жуулчлал, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал” сэдэвт Мөсний баяр, Олон улсын тэшүүрийн марофоныг зохион байгууллаа.

ХБНГУ-ын Берлин хотноо “ITB-2007” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд нэгдсэн зохион байгуулалттай оролцож Монгол Улсыг сурталчиллаа.

Аялал жуулчлалын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Байгаль орчны салбарт:

“Агаарын бохирдлын тухай” болон “Агаарын төлбөрийн тухай” хуулиудын төслийг шинээр боловсруулах ажлын хэсэг байгуулж, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалыг батлуулав.

“Шувууны томууны цар тахлаас сэргийлэх, тэмцэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө” болон “Олон улсын туйл судлалын жилийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө”-г баталлаа.

Халаалтын төвлөрсөн шугамд холбогдоогүй сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэгт цахилгаан болон хийн халаагуур суурилуулах зураг, төсөв боловсруулж экологи-эдийн засгийн үнэлгээ хийх ажлын хэсгийг сайдын тушаалаар байгуулж Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа нам даралтын зуухнаас халаалтаа авдаг өрхийн 50 эмнэлэг, 20 сургууль, цэцэрлэгийн дулааны асуудлыг цахилгаан халаалтад шилжүүлэх асуудлыг боловсруулав.

Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах асуудлаар Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газартай ярилцлага зохион байгуулж “Аюултай хог хаягдлын менежмент” төслийн танилцуулгыг бэлтгэн хүргүүлэв.

“Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн говийн бүсийн дагуух төмөр замын хэсгийг элсний нүүдлээс хамгаалах зорилгоор 400 км гаруй урттай ойн зурвас байгуулах ажлыг “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхээр тогтов.

Завхан аймгийн ойн сангийн нийт талбайг хамарсан ой зохион байгуулалтын үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж дуусгаснаар тус аймгийн 19 сумын нийт 777920 га талбайг хамарсан ойн сангийн нөөц бүртгэгдээд байна.

Ойн үрийн сангаас 22 кг шинэсний үр, 12 кг нарсны үрийг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хуваарилав.

Байгаль орчны сайдын тушаалаар “2007 онд аймаг, нийслэлийн хэмжээгээр ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх замаар бэлтгэх хэрэглээний модны дээд хязгаар”-ыг батлав.

“Усны хомсдлыг даван туулцгаая”, “Туйлын цаг уур, түүний үр дагаварыг ойлгох нь” сэдэвт онол-практикийн бага хурал, усны салбар дундын менежментийг боловсронгуй болгох ажлын хэсгийн хуралдаанууд тус тус зохиогдов.

Монгол Улсын БОЯ болон БНСУ-ын Ойн агентлагийн хооронд “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цөлжилт болон шар шороон түйрэлтэй тэмцэх тухай протокол байгуулж тус протоколын дагуу хоёр тал 2007-2016 оны хооронд ойжуулах төслийг 10 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр тогтов. БНСУ-ын тал 2007 онд 500.0 мянга, 2008-2016 оны хооронд жил тутам 1.0 сая ам. доллартай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж олгохоор боллоо.

АНУ-ын НАСА байгууллагатай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн төвд суурилуулсан агаарын тунгалагшилтыг хэмжих автомат төхөөрөмжийн ээлжит шинэчлэлийг хийхээр тоног төхөөрөмжийг хүлээн авч суурилуулах ажлыг гүйцэтгэв.

Гадаад бодлогын чиглэлээр:



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Франц Улсад 2007 оны 2 дугаар сарын 21-25-нд албан ёсны айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Францын Ерөнхийлөгч Ж.Ширактай хэлэлцээ хийж, Франц Улсын Үндэсний хурлын дарга Ж.Л.Дэбрэ, Сенатын дарга К.Понсэлэ, Гадаад худалдааны асуудал эрхэлсэн сайд К.Лагард нартай уулзав. Мөн айлчлалын үеэр Францын Үндэсний хурлын гишүүн, Үндэсний хурал дахь Франц-Монголын найрамдлын бүлгийн гишүүн Ж.Шартье, Францын уул уурхайн AREVA группийн захирал А.Лувержон, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал К.Мацура нартай тус тус уулзав.

Айлчлалын үеэр манай талаас хоёр орны харилцааны уламжлалт салбарууд болох боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцсоноос гадна цөмийн эрчим хүч, уран баяжуулах салбарт Францтай хамтын ажиллагааг эхлүүлэх асуудлыг хөндөж ярилцав. Талууд мөн олон талт хамтын ажиллагаа, олон улс, бүс нутгийн тулгамдсан асуудлуудаар харилцан байр сууриа илэрхийлэв.

Айлчлалын үеэр Монгол, Францын хамтарсан мэдэгдэл, Иргэний агаарын тээврийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын ҮХЯ, Францын Эдийн засаг, санхүү, аж үйлдвэрийн яам хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг, Ус ба хүрээлэн буй орчны салбарт санхүүгийн тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, Францын Эдийн засаг, санхүү, аж үйлдвэрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг (Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг тохирсон баримт бичиг), Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, Францын Үндэсний хөдөө аж ахуйн судалгааны хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны гэрээ, МҮХАҮТ, Францын Худалдааны танхим хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг зэрэгт тус тус гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Япон Улсад төрийн айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр Японы Эзэн хаан Акихитод бараалхаж, Ерөнхий сайд Ш.Абэ-тай дээд хэмжээний уулзалт хийлээ.

Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхий сайд Ш.Абэ нар Монгол, Японы хамтын ажиллагааг ирэх 10 жилд хөгжүүлэх Үндсэн хөтөлбөрт үсэг зурж, Хамтарсан мэдэгдэл гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Их Британид хийх айлчлалын бэлтгэлийг ханган ажиллаж, айлчлалын асуудлаар Их Британийн Элчин сайд, ЕСБХБ-ны суурин төлөөлөгч нартай уулзав.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш Ерөнхийлөгч Н.Энхбаяртай утсаар ярьж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны тодорхой асуудлаар санал солилцов. Тухайлбал, Ирак дахь Монгол Улсын зэвсэгт хүчний оролцоог үргэлжлүүлэхийг хүсэлт болгов. Монгол Улсын Ерөнхийлөгч Мянганы сорилтын сангаас тусламж авах асуудал удаашралтай байгаад анхаарлаа хандуулахыг болон монголчуудад зориулсан визийн нөхцөлийг хөнгөвчлөх, монголын залуусыг АНУ-ын талын тэтгэлгээр сургах явдлыг нэмэгдүүлэх, АНУ дахь монгол иргэдийг зочин-ажилчны хөтөлбөрт хамруулах, Монгол Улсыг АПЕК-т нэгдэхийг дэмжихийг Ерөнхийлөгч Ж.Бушээс хүсэв. Ерөнхийлөгч Ж.Буш Ерөнхийлөгч Н.Энхбаярыг тааламжтай цагтаа АНУ-д айлчлахыг урив.

Монгол, Канадын дугуй ширээний III уулзалт Оттава хотноо болов. Уулзалтад Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон тэргүүтэй төлөөлөгчид оролцсон бөгөөд Канадын Гадаад хэрэг, олон улсын худалдааны департаментын Зүүн азийн газрын ерөнхий захирал Г.Хоулден, Канадын Гадаад хэрэг, олон улсын худалдааны департаментын Туслах дэд сайд Ж.Фокс нартай уулзаж, хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцов.

Монгол, Кубын ЗГХК-ын 4 дүгээр хуралдаан Гавана хотноо болж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

БНАЛАУ-ын Ерөнхийлөгч Чуммали Саяасон, Үндэсний Ассамблейн дарга Тонгсин Таммавонгийг Монгол Улсад тус тус айлчлуулахад бэлэн байгаагаа Лаосын талд мэдэгдэв.

УИХ-ын дарга Ц.Нямдорж Шинэ Зеланд, Австрали улсуудад албан ёсны айлчлал хийх бэлтгэл ажлыг хангалаа.

Монгол, АНУ-ын хоорондын Консулын конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг солилцох протоколд Гадаад хэргийн сайд Н.Энхболд, АНУ-ын Элчин сайд М.Минтон нар гарын үсэг зурав.

Олон улсын байгууллагуудын татвар, хандивын тухай Засгийн газрын 173 дугаар тогтоолыг шинэчлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэв.

УИХ-ын дарга Ц.Нямдорж, Ерөнхий сайд М. Энхболд Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Я.Ичихашиг хүсэлтээр нь тус тус хүлээж авч уулзан Японы угсаа залгамжлах Ханхүү Нарухитог 7 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд айлчлуулах асуудлыг хөндөж ярилцав.

Японы санхүүгийн жил 4 сарын 1-нээс эхлэхтэй холбогдуулан “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд зурагдсан “ЕБС-дын өргөтгөл, сэргээн засварлалтын хөтөлбөрийн 2, 3 дугаар шат”, “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн ноот бичиг”, “Хар Хорум музейг сэргээн засварлах ноот бичиг”, “Зүүн чиглэлийн замын төсөл”-ийн ноот бичгүүдийн хугацааг сунгаж санхүүжилтийг ирэх оны төсвийн жилд үргэлжлүүлэн авах талаар хүсэлт тавьж шийдвэрлүүлэв.

“Төр, засгийн гадаад бодлого, олон улсын харилцааны зарим асуудлаар баримтлах байр суурь” лавлах материалыг боловсруулж, хэлэлцүүлэхээр ҮАБЗ-д хүргүүлэв.

Манай улсаас Польшид төлөх өрийг зохицуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Польшийн их, дээд сургуулиудад суралцах монгол оюутнуудад тэтгэлэг олгох асуудлаар хоёр орны БСШУЯ хооронд “Тэтгэлгийн хөтөлбөр”-ийг байгуулж, үзэглэв.

НҮБ-ын Ардчиллын сангийн шугамаар хэрэгжүүлэх МХЗ-9 төслийн баримт бичгийг баталгаажуулах баримтад Засгийн газрыг төлөөлж Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон гарын үсэг зурав. Мянганы хөгжлийн зорилтуудын асуудлаар Ханой хотноо болсон Зүүн Ази болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн форумд ГХЯ-ны ТНБД Х.Бэхбат тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

Монгол, Оросын бизнес эрхлэгчид 90 хоногийн хугацаагаар харилцан зорчиход олон удаагийн нэг жилийн визийг олгож байхыг хүсэж ОХУ-ын ЭСЯ-нд ноот гардуулав.

Гадаад хэргийн сайд Н.Энхболд АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн орлогч Т.Стратфорд, Элчин сайд М.Минтон нарыг тус тус хүлээн авч уулзав.

Элчин сайд Р.Хатанбаатар Тажикийн Ерөнхийлөгч Э.Рахмонд Итгэмжлэх жуух бичгээ барилаа.

Батлан хамгаалах салбарт:

“Зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаар тогтоолгох тухай”, “2007 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын тоо, цэрэг халалт, таталтын хугацаа тогтоох тухай”, “Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулах төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

Мөн “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд сургалтын хөдөлгөөнт багийн дараагийн ээлжийг илгээх тухай асуудлыг шийдвэрлэлээ.

“Монгол цэргийн урлагийн тулгамдсан асуудлууд” Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа.

“Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцсон цэргийн багийн бүрэлдэхүүнийг “Энхийн төлөө” медалиар шагнуулахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт өргөн мэдүүлсэн.

Зэвсэгт хүчний 86 жилийн ойн баярын арга хэмжээг Бөхийн өргөөнд зохион байгуулж, Батлан хамгаалахын оны тэргүүний офицер, ахлагч, ажилтан албан хаагчдыг шалгаруулан шагнал гардуулж, зарим тэргүүний албан хаагчдыг Төрийн дээд шагнал болон салбарын шагналаар шагнуулах арга хэмжээг зохион байгууллаа.

АНУ, Монгол Улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх 1.0 сая ам. долларын болон бусад тусламжийг хүлээн авч дууслаа.

“Үхэлд үл хүргэх зэвсгийн семинар-2007” олон улсын семинарын анхан шатны төлөвлөлтийн бага хурлыг АНУ-ын Номхон далайн цэргийн командлалтай хамтарч Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлого, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй цэргийн албан хаагчдын ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг “Соёмбо”, “Зууны мэдээ” сонинтой хамтран зохион байгуулж, Монголын радиотай хамтран “Дайчидтай ярилцах цаг” нэвтрүүлгийг бэлтгэн явууллаа.

Косово дахь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй Олон үндэстний зүүн хойд дивизийн Митровица хотод байрлах Францын батальоны бүрэлдэхүүн дэхь Бельгийн Вант Улс, Монгол Улсын хамтарсан ротын бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн манай цэргийн багийнхан үүрэг даалгавраа амжилттай биелүүлээд эх орондоо хүрэлцэн ирлээ.

“Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй цэргийн багийн автотехникүүдэд шаардлагатай байгаа сэлбэгийг нийлүүлэх, Зэвсэгт хүчний 8 ангийг 18 нэгж автомашинаар нөхөн хангах ажлыг зохион байгуулаа.

Хууль зүйн чиглэлээр:

Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан Захиргааны хариуцлагын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг тус тус боловруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн банкны хооронд байгуулсан “Боловсролын салбарыг хөгжүүлэх 3 дахь шатны төслийн зээлийн хэлэлцээр”-т хууль зүйн дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд БНСУ-д ажлын айлчлал хийж, БНСУ-ын Хууль зүйн сайдтай уулзан “Иргэний болон худалдааны асуудлаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ”, “Хүн худалдахтай тэмцэх талаар хамтран ажиллах тухай МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “БНСУ-ын Хууль зүйн яам, МУ-ын Хууль зүй, дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны гэрээ”, “Яам хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг”-ийн төслийг гардуулсан болно.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид Германы үнэт цаас, гадаад паспортын хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор ХБНГУ-д албан томилолтоор ажиллалаа.

“Палермогийн конвенц ба үндэсний хууль тогтоомж” сэдэвт олон улсын бага хурлыг эхлэн зохион байгуулж, гадаад, дотоодын нийт 150 гаруй төлөөлөгчдийг оролцууллаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 10, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 4, төрийн бус байгууллага 85, шашны байгууллага 6-г улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгов.

Эрх зүйн мэдээллийн цахим санд шинээр Улсын Их Хурлын 19, Үндсэн хуулийн цэцийн 36 тогтоол, Улсын Дээд шүүхийн 2 тогтоол, Засгийн газрын 21 тогтоол, нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн 79 актыг орууллаа.

Гадаад орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 14 байгууллага, аж ахуйн нэгж, 98 гадаадын иргэн, 1 уригчид Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу арга хэмжээ авч, 23200.0 мянган төгрөгийг улсын орлогод оруулжээ.

Онцгой байдлын албаны чиглэлээр:

“Гамшгаас хамгаалах тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Шувууны томуу, томуугийн цар тахлаас сэргийлэх, тэмцэх бэлэн байдлыг хангах үндэсний төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Говьсүмбэр, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт цэцэг өвчний хорио цээрийн дэглэмийг цуцлаад байна.

Харин аймгийн Засаг даргын захирамжаар Хэнтий, Төв аймгийн зарим сумдыг гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хорио цээрийн дэглэм тогтоон мөрдөж байна.

“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын албан даалгаврыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хэлтсүүдэд хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Засгийн газрын 2007 оны 44 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, батлагдсан удирдамжийн дагуу Улсын нөөцийн салбаруудын нөөцийн бараа, материалд тооллого явуулж, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын байдалд шалгалт хийж байна.

Архангай, Ховд, Увс аймгийн Өндөр-Улаан, Эрдэнэбулган, Жаргалант, Бөхмөрөн сумдад боом өвчний тохиолдол гарсан тул хорио цээрийн дэглэмийг тогтоож, халдвар авч өвчилсөн хүмүүсийг эмчилж, үхсэн малыг устган халдваргүйжүүлж, голомтод байсан 43 өрхийн 186 хүн, 22870 гаруй малыг вакцинжуулах арга хэмжээ авлаа.

Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал унтраах ангиуд 195 удаагийн гал түймрийг унтраасны зэрэгцээ аврах ажиллагаа явуулж төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 342.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан бөгөөд гал түймрийн улмаас 10 хүн амь насаа алдаж, 6 хүн түлэгдэж гэмтсэн байна.

Энэ сард Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Халиун, Хангал, Хонгор, Орхон, Хужирт суманд ой, хээрийн түймэр 6 удаа гарч, гал унтраах ажилд аймгуудын Онцгой байдлын хэлтсийн 112 албан хаагч, орон нутгийн 182 иргэн, 13 автомашин ажилласан байна.

3 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд болсон хүчтэй цасан болон шороон шуурганы улмаас Дархан-Уул, Дундговь, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Хэнтий аймгийн зарим сум, нийслэлийн зарим дүүргүүдэд 14 байшингийн дээвэр хуурч, өндөр хүчдэлийн 30 шон унасныг тогтоож, сэргээн босгох арга хэмжээ авч байна.

Мөн энэ үеэр Дундговь, Дорноговь, Хэнтий аймагт төөрсөн 6 хүнийг эрэн хайх ажиллагааг харьяа Онцгой байдлын хэлтсийн аврагчид, нутгийн иргэд зохион байгуулж 5 хүнийг эсэн мэнд олсон бөгөөд 1 хүн осгож нас барсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар